

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

№23-06

Энэхүү гэрээг Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 52 дугаар зүйлийн 52.2.11 дэх заалтыг тус тус үндэслэж нэг талаас **Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ** (цаашид “Сайд” гэх), нөгөө талаас **Говьсүмбэр аймгийн Засаг дарга Г.Батсуурь** (цаашид “Засаг дарга” гэх) нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) хамтран байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь байгаль орчин, аялал жуулчлалын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа орон нутагтай хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

ХОЁР. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Талууд Байгаль орчны багц хуулиуд, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Ойн тухай, Усны тухай, Хог хаягдлын тухай, Аялал жуулчлалын тухай, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллана.

ГУРАВ. САЙДЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлын менежментийг сайжруулах, ойн нөөцийг нэмэгдүүлэх, байгаль орчныг нөхөн сэргээх, зохистой ашиглах, байгаль орчны тэнцлийг хангах, байгаль орчинд учирч болох хохирлоос урьдчилан сэргийлэх, хохирлыг арилгуулах, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжих, аялал жуулчлалын бодлогоор хангах чиглэлээр тодорхой асуудлаар орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудад удирдлага, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, биелэлтийг хангуулах.

3.2. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу тус гэрээний хавсралтад туссан арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах, биелэлтэд хяналт тавих, ажлын гүйцэтгэлтэй холбоотой асуудлаар шаардлага тавих.

3.3. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж буй арга хэмжээний явцад хяналт тавьж, хугацаа хоцрох, чанарын шаардлага хангаагүй тохиолдолд уг ажлыг чанартай хийхийг шаардах, дурьдсан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд эрх шилжүүлэхээс татгалзах. Эрх шилжүүлсэн ажлын явцтай танилцаж, үнэлэлт дүгнэлт өгөх, ажлын тайланг хүлээн авч танилцах.

3.4. Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь заалтын дагуу салбарын холбогдох хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон сайдын шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж нөхцөл байдалтай орон нутагт танилцаж ажиллах.

3.5. Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтын дагуу Гэрээний биелэлтийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих зорилгоор хагас жилийн ажлын

биелэлтийг тайлагнахад Байгаль орчин, аялал жуулчлалын яамны ажлын хэсгийг орон нутагт томилж ажиллуулах.

ДӨРӨВ. ЗАСАГ ДАРГЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Засаг дарга нь байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг орон нутагтаа зохион байгуулж, байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авч хэрэгжүүлж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийн биелэлтийг хангуулах.

4.2. Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.4, 23 дугаар зүйлийн 23.8.4-23.8.9, 60 дугаар зүйлийн 60.3.6, 65 дугаар зүйлийн 65.1.6 дахь заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан эрх, үүргийг хэрэгжүүлэх.

4.3. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 1, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1-3.4 дэх заалтын дагуу олсон орлогыг зөвхөн хууль тогтоомжид заасны дагуу зарцуулах.

4.4. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлэх зорилгоор 2022 онд орон нутгийн төсөвт төвлөрсөн байгалийн нөөц ашигласан орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр зарцуулах.

4.5. Төсвийн ерөнхийлөн захирагчаас Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын гүйцэтгэгчийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Монгол Улсын ерөнхий сайдын 2022 оны 02 дугаар албан даалгаврын дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулан, гүйцэтгэлд хяналт тавих.

4.6. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байгаль орчин, аялал жуулчлалын салбарт дэвшүүлсэн зорилтуудыг хангуулах ажлыг эрхэлж, үйл ажиллагааг өөрийн аймгийн нутаг дэвсгэрт зохион байгуулах.

4.7. Аймаг, Нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргыг ажилд томилох, ажлаас чөлөөлөхдөө байгаль орчин, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөх.

4.8. Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1-9.3.13; 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.1-14.8, 15 дугаар зүйлийн 15.1, 16 дугаар зүйлийн 16.1-16.9, 17 дугаар зүйлийн 17.1-17.7, 40 дүгээр зүйлийн 40.1-40.8, 41 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх.

4.9. Байгаль орчны багц хууль, холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, ир эдийн байгаль орчныг хамгаалах талаарх эрх зүйн боловсролыг орон нутагтаа түгээх ажлыг зохион байгуулах.

4.10. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулж, орон нутгийн төсөвт хуулийн дагуу төвлөрсөн орлогыг байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээнд 100 хувь хүртэл зарцуулах.

4.11. Байгаль орчин, аялал жуулчлалын газарт аймгийн мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч нар шилжин очиж байгаатай холбогдуулан тэдний ажиллах нөхцөлийг сайжруулах, хяналт шалгалтын ажилд дэмжлэг үзүүлэх.

ТАВ. УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

5.1. Улсын төсвийн хөрөнгөөр орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхдээ энэхүү гэрээний 4.5-д заасны дагуу сонгон шалгарсан гүйцэтгэгчтэй

захиалагч, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар гурвалсан гэрээ байгуулж санхүүжүүлнэ.

5.2. Орон нутгийн төсвөөс болон Улсын төсвөөс санхүүжүүлэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, бохирдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг сурталчлах, аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээг тус гэрээний 1 дүгээр хавсралтад тусгасны дагуу зохион байгуулна.

ЗУРГАА. ГЭРЭЭГЭЭР ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

6.1. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх үүрэгтэй. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлээгүй нь Төрийн албаны тухай, Төсвийн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээх нөхцөл бүрдсэн бол зохих хариуцлагыг хүлээнэ.

ДОЛОО. ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

7.1. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах бол Талууд бичгээр үйлдэн гарын үсэг зурж, баталгаажуулна. Гэрээний нэмэлт, өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.

НАЙМ. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

8.1. Энэхүү гэрээг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал нэг жилийн хугацаатай байгуулж хоёр хувь үйлдэнэ. Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

ЕС. БУСАД


9.1. Аймаг, Нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь 2023 оны гэрээний хэрэгжилтийг 2 дугаар хавсралтын дагуу хагас жил (2023 оны 6 дугаар сарын 15-ны дотор) болон бүтэн жилээр биелэлтийг гаргаж (2023 оны 12 дугаар сарын 01-ний дотор), Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд ирүүлнэ. Түүнийг үндэслэн Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу дүгнэж, нэгтгэн Сайдад танилцуулна.

9.2. Талууд байгаль орчныг хамгаалах ажилд үр дүнтэй ажилласан албан хаагчдад байгаль орчин, аялал жуулчлалын салбарын болон Аймаг, Нийслэлийн Засаг даргын нэрэмжит шагнал урамшуулал олгож болно.

9.3. Талууд энэхүү гэрээг 2024 онд шинэчлэн байгуулах ба гэрээнд тусгагдах ажлын саналыг 2023 оны 10 дугаар сарын 15-наас 2023 оны 11 дүгээр сарын 30-ны дотор багтаан солилцон авч 2023 оны 12 дугаар сарын 10-ны дотор гэрээний төслийг боловсруулан, харилцан тохиролцсон байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД


Б.БАТ-ЭРДЭНЭ

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА


Г.БАТСУУРЬ

Говьсүмбэр аймгийн байгаль орчин, аялал
жуулчлалын салбарт хамтран ажиллах
23-06 дугаар гэрээний хавсралт

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилгот түвшин (тоо хэмжээ)	Хугацаа	Зардал (сая.төг)
1. Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангах						
1	Хууль бус ан агнуур, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчлийг бууруулах зорилгоор эргүүл шалгалт зохион байгуулах	- Хяналт шалгалтын тоо - Илрүүлсэн зөрчлийн тоо - Зарцуулсан төсөв /мян.төг/	15 0 1,500.0	16 1 3,700.0	3-5, 9-11 сард	БХНСАХЗ 3.7
2	Е-mongolia цахим системээр иргэдэд үйлчилгээ үзүүлэх (Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргах үйл ажиллагаа, Ус ашиглуулах дүгнэлт, цооног ерөмдөх худаг гаргах зөвшөөрөл олгох үйл ажиллагаа гэх мэт)	- Цахимаар үзүүлсэн үйлчилгээний төрөл - Цахимаар үйлчилгээ авсан иргэн, аж ахуйн нэгж	4 21	4 20-оос доошгүй	I-IV улирал	
3	Байгалийн нөөцийн хамтын менежментийн нехөрлөлийн үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллах	- БНХМН-д дэмжлэг үзүүлсэн тоо - Хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагаа - Зарцуулсан зардал	1 4 1,000.0 мян.төг	1 4 1,500.0	I-IV улирал	Сумын БХНСАХЗ
4	Байгаль орчны мэдээллийн санг сайжруулах (eic.mn)	- Мэдээлэл оруулсан хугацаа - Мэдээллийн санд оруулсан мэдээллийн тоо - Цэнэр	2 сарын 10 Үнэн зөв	2 сарын 15-ны дотор Үнэн зөв	I улирал	

5	5	Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж болон улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн, орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, тогтвортой хөгжлийн боловсрол олгох арга хэмжээ	<ul style="list-style-type: none"> - Зохион байгуулсан арга хэмжээ - Хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо - Сургалт - Аян - Уралдаан - Гарын авлага тараасан хүний тоо - Зарцуулсан зардал 	<p>23</p> <p>1178</p> <p>19</p> <p>3</p> <p>1</p> <p>590</p> <p>2.800.0</p>	<p>25</p> <p>1500</p> <p>20</p> <p>3</p> <p>2</p> <p>650</p> <p>5.000.0</p>	I-IV улирал	БХНСАХ3 10.0
6	6	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийлгэх төсөл, арга хэмжээний төсөв хийлгэх	Төсөв хийлгэсэн төлө, арга хэмжээ	Шинэ ажил	2	I-IV улирал	БХНСАХ3 6.0
7	7	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын хэрэгжилтийг хангах, хуулийн хэрэгжилтийг 100 хувьд хүргэх	- Хууль, журмын хэрэгжилт	100 хувь	100 хувь	I-IV улирал	
8	8	2024 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хувь хэмжээ, орлогоос зарцуулах арга хэмжээний төлөвлөлтийг Байгаль орчны төсөв зардлын мэдээллийн санд журамд заагдсан хугацаанд тогтмол оруулах (www.eic.mn)	- Мэдээллийн санд оруулсан байдал /хугацаа, чанар/	100 хувь	100 хувь	I-IV улирал	
2. Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах							
9	1	Байгаль орчинд ээлтэй, үр ашиггүй, хэмнэлттэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтыг (ногоон худалдан авалт) дэмжих	Аймгийн ногоон худалдан авалтын эзлэх хувь	10 хувь	10 хувь	I-IV улирал	
10	2	Байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээ, үйлдвэрлэлийг нэвтрүүлэх	Байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээ, үйлдвэрлэл нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийн тоо	6	7	I-IV улирал	

3. Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийг хамгаалах

11	1	"Жорлонгоо өөрчилъё" аяныг хэрэгжүүлж, хөрс бохирдуулагч жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулж, стандарт хангасан жорлонтой болох арга хэмжээ авах	- Зохион байгуулсан арга хэмжээ - Жорлонгоо өөрчилсөн аж ахуйн нэгж, өрх - Хамтран ажилласан байгууллага	3 6 52 өрх 6	3 6 55 өрх 6	I, II, III, IV улирал	
12	2	Аймгийн хэмжээнд хог хаягдлыг бууруулах, ангилан ялгах үйл ажиллагааг эрчимжүүлж, хоёрдогч түүхий эд цуглуулж, боловсруулж байгаа иргэнийг бодлогоор дэмжиж ажиллах	- Дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан байдал - Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээ - Ангилан ялгасан хог хаягдлын хэмжээ	2 4 5 тн хуванцар, 17510 шил, 3 тн борцаас	2 5 3 Гүйцэтгэл	I-IV улирал	
13	3	Нутаг дэвсгэрийн хэмжээнд аюултай хог хаягдлын талаар хуулийн хэрэгжилтийг хангаж, хадгалалт хамгаалалтанд хяналт тавьж, аюултай хог хаягдлын тооллого зохион байгуулах	- Хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо - Тооллогын үр дүн - Хяналт тавьсан тоо	7 1	7 - 4	I-IV улирал	
14	4	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны А-429/257 дугаар тушаалаар батлагдсан "Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч импортлогч нь хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалт"-ын хэрэгжилтэд хяналт тавих	- Үүссэн хог хаягдлыг үйлдвэрлэгчид буцаан нийлүүлэхэд хяналт тавьсан тоо - Зохион байгуулсан арга хэмжээ, буцаан нийлүүлсэн бүтээгдэхүүний төрөл, тоо хэмжээ	Шинэ ажил	1 3 200	I-IV улирал	
15	5	Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.12-т заасны дагуу батлагдсан Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журам"-ыг хэрэгжүүлэх	- Олон нийтийн байцаагчийн тоо - Илрүүлсэн зөрчлийн тоо - Урамшууллын дүн	2 5 6,360.0	2 5-аас доошгүй 7,000.0	I-IV улирал	Сумдын БХНСАХЗ
16	6	"Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах,	- Зохион байгуулсан арга хэмжээ	-	2	I-IV улирал	ОНХС 1.0

17	7	сэргээн ашиглах, устгах, булшлах журам"-ыг олон нийтэд таниулах, сурталчлах	<ul style="list-style-type: none"> - Агаарын бохирдуулагч эх үүсвэрийн тоо - Галлагаатай зуухны тоо - Усан халаалттай зуухны тоо - Түлшний зарцуулалтын хувь - Хөдөлгөөнт эх үүсвэрийн тоо - Хөрс бохирдуулагч жорлонгийн тоо - Өмнөх оны харьцуулалтын хувь 	Гүйцэтгэл	Агаар орчны бохирдлын улмаас хүний эрүүл мэндэд учруулж байгаа урт болон богино хугацааны сөрөг нөлөөллийн талаар бодитой тооцоо судалгаагаар болно.	3,4-р улирал	ОНХС 0.5
18	8	Байгаль орчны статистик мэдээллийн маяг / БОХ 6.1; 6.2; 6.3/, түүнийг хэрхэн боловсруулах талаарх сургалт зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - Зохион байгуулсан сургалтын тоо - Хамрагдсан сум - Хамрагдсан албан хаагчийн тоо 	1 3 6	2 3 6	I-IV улирал	-
19	9	"Нөхөн сэргээлт-2024" нэгдсэн арга хэмжээний хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран туурь хог хаягдалтай талбайд техникийн нөхөн сэргээлт хийх	<ul style="list-style-type: none"> - Туурь хог хаягдалтай газрын нөхөн сэргээлт /га/ - Зарцуулсан зардал 	11 га 3,500.0	12 га 4,000.0	I-IV улирал	ОНХС 4.0
20	10	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдийн нөхөн сэргээлтэд хяналт тавьж ажиллах	<ul style="list-style-type: none"> - Нөхөн сэргээлт хийсэн талбай 	4.5 га	5 га	II улирал	Хувийн хөрөнгө оруулалт
21	11	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулах ЗР цогц менежментийг хэрэгжүүлж эдийн засгийн эргэлтэд оруулах	<ul style="list-style-type: none"> - Хэрэгжүүлсэн арга хэмжээ - Ангилан ялгасан хог хаягдлын хэмжээ 	4 5 тн хуванцар, 17510 шил, 3 тн борцаас	5 Гүйцэтгэл	I-IV улирал	

25	12	Аймаг, нийслэлийн хэмжээнд эвдэрсэн газрын тооллого хийж, байгаль орчны мэдээллийн санд оруулах	- Аймгийн хэмжээнд эвдэрсэн газрын тооллогын ажлыг зохион байгуулж мэдээллийн санд оруулсан байдал	Эвдэрсэн газрын тооллого судалгааны мэдээллийн сан үүсээгүй.	Эвдэрсэн газрын бүртгэл, судалгаа, орон зайн мэдээлэл шинэчлэгдэж мэдээллийн санд оруулсан байна.	II, III улирал	Орон нутгийн төсөв
26	13	Эвдэрч, эзэнгүй орхигдсон талбайд нөхөн сэргээлт хийх	- Нөхөн сэргээлт хийсэн талбай - Орон нутгийн төсвөөс зарцуулсан зардал	5.2 га	10 га-аас доошгүй	Жилдээ	Орон нутгийн төсөв
27	14	"Нөхөн сэргээлт-2024" нэгдсэн арга хэмжээний аймгийн дэд ажлын хэсгийн үйл ажиллагааг эрчимжүүлж, дэмжиж ажиллах	- Ажлын хэсгийг үйл ажиллагааг хэвийн явуулах санхүүжилтийг шийдвэрлэсэн байна.	Дэд ажлын хэсгийн төлөвлөгөөний биелэлт гаргасан	Ажлын хэсгийн үйл ажиллагааг эрчимжүүлсэн байна.	Жилдээ	Орон нутгийн төсөв
28	15	Зэрлэг амьтдын байршил бүхий газарт биотехникийн арга хэмжээ авах	- Улсын тусгай хамгаалалттай газар нутагт - Биотехникийн арга хэмжээ авсан байна.	-	Улсын тусгай хамгаалалттай газар нутаг	Жилдээ	2.5
29	16	Тураг гогойн тархац нөөцийн судалгаа	- Гол мөрөн нууруудын судалгаа	Аймгийн хэмжээнд хийгдсэн байна.	Тархац нөөцийн судалгааг улирлаар хийсэн байна.	Жилдээ	Орон нутгийн төсөв
30	17	Хууль бус анг таслан зогсоох талаар холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах	- Хууль бус ангийн гэмт хэрэг багассан байх	Бүх сумдууд	Хуулийн сургалт сурталчилгаа хийсэн байна.	Жилийн турш	Орон нутгийн төсөв
4. Усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах							
31	1	Булгийн эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг зохион байгуулах	Хашиж хамгаалсан булгийн тоо Зарцуулсан зардал	1 6,500.0	1 7,000.0	II улирал	БХНСАХЗ 7,000.0

32	2	Зарим булаг рашааны хашаа, өмнө онуудад хийгдсэн болон бусад тохижилтын ажлыг сэргээн, засварлах	Сэргээн засварласан булаг, уст цэгийн тоо Зарцуулсан зардал	Шинэ	2 22,540.0	Жилдээ	БХНСАХЗ 22.540.0
33	4	Усны сав газрын саналыг үндэслэн сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээ Хамрагдсан хүний тоо Зарцуулсан зардал	Шинэ ажил	1 4,500.0		БХНСАХЗ 4.5
34	5	Усны нөөцийг бохирдож, хомстохоос хамгаалах зорилгоор гадаргын усны тоо бүртгэл зохион байгуулах	Гадаргын усны тооллогын дүн Тайлан хүргүүлсэн байдал /БОАЖЯ, Усны газарт/	Усны тоо бүртгэл хийсэн. Үүнд: Булаг 20, гол 6, нуур, тойром 9, рашаан 1, хөв, цөөрөм 3, баянбүрд 1, газрын доорх усны орд 7, худаг 433 тоологдсон.	Гадаргын усны тооллогын дүн 2 удаа /БОАЖЯ, Усны газарт/	III улирал	Орон нутгийн БХНСАХЗ 4.250.
35	6	Усны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4-т заасны дагуу усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс, ус хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн мужийн заагийг ИТХ-аар тогтоож, Хууль зүйн яаманд бүртгүүлж, дэглэмийг мөрдүүлж, тэмдэгжүүлэх	- Гарсан шийдвэр - ХЗЯ-нд бүртгүүлсэн байдал - Дэглэмийг мөрдүүлэх - Тэмдэгжүүлсэн усны эх үүсвэрийн тоо	Эрүүл ахуйн бүс тогтоосон эх үүсвэрийн тоо- 32	3	Жилдээ	
36	7	Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, тэжээгдлийн мужид байгаа зуслан, суурьшлын бүсийн байгаа айл өрхөд хөрс, усанд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх технологи, гарц шийдлүүдийг тодорхойлж, сурталчилан таниулж, хэрэгжүүлэх	- Зохион байгуулсан арга хэмжээ	Тэрэгтийн усан хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсэд байгаа айл өрх 20 Гарын авлага тараасан	10-аас доошгүй өрх	Жилдээ	

37	8	Ус бохирдуулагчийн эх үүсвэрийн тооллого хийх	- Тооллого байгуулсан байдал	Тооллого зохион байдал	Шинэ	Тооллого зохион байгуулна	Жилдээ
5. Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах							
38	1	Орчны бүсийн менежментийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах	Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээ	2	2	2	I-IV улирал
39	2	"Чойрын богд уул" улсын тусгай хамгаалалттай газар нутгийг өргөтгөх асуудлыг шийдвэрлүүлэх	Өргөтгөсөн талбай	Шинэж ажил	1	1	I-IV улирал
40	3	Улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөрчлөөс урьдчилан сэргийлэх хамтарсан хяналт шалгалт хийх	Улсын тусгай хамгаалалттай Чойрын богд уул	Цагдаагийн газар, сумын ЗДТГазартай тогтмол зохион байгуулдаг	Хяналт шалгалт 4-өөс доошгүй		I-IV улирал
41	4	Улсын тусгай орчны бүсэд амьдарч буй иргэдэд Байгаль орчныг хамгаалах чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээ Хамрагдсан иргэн	2022 онд 30 иргэдэд сургалт хийж, мэдээлэл өгсөн.	Тусгай хамгаалалттай газар нутагт сургалт сурталчилгааг 4 доошгүй удаа зохион байгуулсан байна.		I-IV улирал
42	5	Улсын тусгай хамгаалалттай газар нутаг амьдардаг малчин иргэдтэй газар ашиглах гурвалсан гэрээ байгуулах	Улсын тусгай хамгаалалттай сумдын малчин иргэд	Газар ашиглах гурвалсан гэрээ байгуулсан иргэн	Тусгай хамгаалалттай газар нутаг бүхий сумдын малчин иргэдийн гурвалсан гэрээг шинэчлэн байгуулсан байна.		Жилдээ
43	6	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 29.3 т заасан Байгалийн нөөц, дурсгалт газрын хамгааллыг эрхлэх	Улсын тусгай хамгаалалттай Байгалийн нөөц, Дурсгалт газруудын сдоо хэрэгжүүлж байгаа тогтвортой менежментийн үйл	Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын	Чойрын Богд уулын байгалийн нөөц газрууд		-

		ажиллагааг сайжруулж дэмжлэг үзүүлсэн байна.	Тогтвортой менежментийн сайн туршлагыг сайжруулан тухайн орон нутгийн онцлогт тохируулсан шийдвэрүүдийг гаргуулах			
6. Ойн нөөцийг хамгаалах, Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг өрнүүлж, хэрэгжилтийг хангах						
44	1	Байгалийн болон таримал ойн санг нэмэгдүүлэх, өмнө хийгдсэн хамгаалалтын зурвасын арчилгаанд дэмжлэг үзүүлэх /сум дундын Ойн анги/	Дэмжлэг үзүүлсэн тоо Зарцуулсан төсөв	6 131,746.4	6 30,120.0	I-IV улирал БХНСАХ333 0.120.0
45	2	Ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах Байгалийн ойн санд шинэ тарилт хийх нөхцөл бүрдүүлэх зорилгоор шинээр ойжуулах, талбайн хамгаалалтын хашаа барих / Хэрлэн гол дагуу 3 га /	Шинээр ойжуулсан талбай /га/ Зарцуулсан зардал	Шинэ ажил	3 28,702.0	I-IV улирал БХНСАХ332 8.702.0
46	3	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн хэмжээний нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Шинэ ажил	1	БХНСАХ332 5.818.0
47	4	Ойн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд байгалийн ойн сангийн сэргэн ургалтад дэмжлэг үзүүлэх сөөгний нөхөн тарилт хийх / Чойрын богд уул/	Тарьсан модны тоо Зарцуулсан зардал	Шинэ ажил	100 2,500.0	БХНСАХ3 2.500.0
48	5	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан мод, сөөгний мөнгөн урамшуулал олгох	Урамшуулал олгосон, иргэн, аж ахуйн нэгж Олгосон урамшуулал Тарьсан модны тоо	3 16 32,625.0 2110	Гүйцэтгэл	БХНСАХ3 49.950.0

49	6	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд шинээр мод үржүүлгийн газар байгуулж, үрийн нөөц бүрдүүлэх	Мод үржүүлгийн газар байгуулах Тарьц суулгацын нөөцийн хэмжээ	2	1	I-IV улирал	
				15000	56000		
50	7	Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг орон нутагт зохион байгуулж, бүх нийтээр мод тарих аяныг өрнүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Тарьсан мод бугны тоо Хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж Шинээр бий болгосон ойн зурвас /га Ургалт, амьдралтын хувь	3 54251 220/ 3499 4 81	3 55000 - 10 85	5,10 дугаар сард	УТ, ОНТ, БУСАД
51	8	Мод үржүүлэг, ойжуулалт, ойн зурвас, суурин газрын цэцэрлэгжүүлэлтийн зориулалтаар ажил хийх хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгж, иргэдэд шаардлагатай газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган, холбогдох хууль, журмын дагуу шуурхай шийдвэрлэж ажиллах	Зохион байгуулсан арга хэмжээ Олгосон газар Тусгай хэрэгцээнд авсан газрын хэмжээ	Шинэ ажил	Гүйцэтгэлээр	I-IV улирал	

7. Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар

52	1	Аялал жуулчлалын байгууллагуудын хүний нөөцийг чадавхижуулах	Хамрагдсан сургалт Хамрагдсан хүн Зарцуулсан зардал	3 70 1.3 сая төгрөг /ОНХС/	4 75 1,000.0	I-IV улирал	БХНСАХЗ 1.0
53	2	Тусгай хамгаалалттай газарт түшиглэсэн аялал жуулчлалын эвент арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	Зохион байгуулсан боржигин өв соёлын эвент арга хэмжээ Хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж	Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан зохион байгуулагдааг үй.	3 50	III улирал	БХНСАХЗ 8.0
54	3	Байгаль, түүх соёлын /Боржигин өв соёл/ аялал жуулчлалын эвентыг орон нутгийн онцлогт тулгуурлан зохион байгуулах	Зохион байгуулсан боржигин өв соёлын эвент арга хэмжээ Дотоодын аялагчдын оо	1	2	III улирал	ОНХС 6.0

		Гадаад жуулчны тоо	3500 87	7000 210		
55	4	Аялагч, амрагчдын зүй зохистой аялах соёл дадлыг төлөвшүүлэх нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах	Аялагч, амрагчдад нөлөөллийн ажил Хамрагдсан хүн	зориулсан 5 75 1,930.0	5 100 4,500.0	ОНХС БХНСАХЗ 4.5
56	5	Аймгийн аялал жуулчлалын нэгдсэн танилцуулга нугалбар шинэчилж хэвлүүлэх	Аялал жуулчлалын танилцуулга	-	1000	ОНХС 3.5
57	6	Олон улсын ITM /International travel mart/ болон дотоодын UB тур зэрэг олон улсын үзэсгэлэнд оролцож аймаг, орон нутгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах	Оролцсон үзэсгэлэнгийн тоо Хамрагдсан байгууллагын тоо	2 10	2 5	ОНХС 2.5
58	7	Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, түншлэлийн холбоог сайжруулж, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх санал санаачилгыг дэмжих	Хамтран ажилласан арга хэмжээний тоо	3	3-оос доошгүй	ОНХС 2.0
8. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох						
59	1	Байгаль орчны салбарын хууль тогтоомжийг сурталчилах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох талаар олон нийтэд тогтвортой хөгжлийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээ Сургалтын тоо: Хамрагдсан хүний тоо	нөлөөллийн 21 18 1178	22 20 1500	БХНСАХЗ 28,750.0
9. Биологийн олон янз байдлыг хамгаалах						
60	1	Агнуурын бүс болон ТХГН-т амьтны тооллого зохион байгуулах	Тооллогын үр дүн Зарцуулсан зардал	Шинэ ажил	Толлогын тайлан	БХНСАХЗ 4.520.
61	2	Байгалийн давагдашгүй хүчин зүйл тохиох нөхцөлд зэрлэг амьтдад зориулж биотехникийн арга хэмжээ авах	Өвс Хужир Давтамж Зарцуулсан төсөв	210 2.5 тн 5 2,000.0	210 2,5 тн 6 3,650.0	БХНСАХЗ 3.650